

## УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ӨМНӨД СОЛОНГОС: ТҮГШҮҮРТЭЙ БАЙДЛЫН  
НЭГ ГОЛОМТ****Д. Баярхүү**

Солонгосын хойгийн байдлыг хэвийн болгож, тус бус нутгийн хурцадмал байдлыг намжаах явдал—Алс дорнод дахь олон улсын харилцааны чухал асуудлын нэг болоод байна. Солонгосыг энх тайван замаар нэгтгэж, тус хойгт бат бэх энх тайван тогтоох асуудал нь Солонгосын ард түмний дотоодын хэрэг боловч энэ районы энх амгалан байдлыг сахин хангах зорилт өнөөдөр бүх улс түмнийг түгшүүлж байна. Солонгосын асуудал бол нийгэм—улс төрийн эсрэг тэсрэг хоёр систем, гадаад бодлогын эрс тэс хоёр шугамын олон жилийн гүн гүнзгий тэмцлийн түүх болоод байна. Чухамхүү үүнд л энэ асуудлын гол учир утга, олон улсын агуулга нь байгаа юм.

Солонгосын Хөдөлмөрийн Нам (СХН), Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын (БНАСАУ) засгийн газар Солонгосын хуваагдмал байдлыг энх тайван замаар шийдвэрлэж, Солонгос үндэстэн нэгдмэл нэг гэр бүлд нэгдэн нягтрах бодлогыг тууштай баримталж байгаа бөгөөд ах дүү социалист орнууд, түүний дотор энхийг эрхэмлэгч БНМАУ-ын зүгээс халуун дэмжлэгийг олж байдаг юм. 1980 оны аравдугаар сард хуралдсан СХН-ын VI их хурал Солонгосын нэгдлийн асуудалд ихээхэн анхаарал тавьсан билээ. Их хуралд тавьсан СХН-ын Төв Хорооны тайлан илтгэлд, «Хуваагдмал байдал нь улс орон мөхөл сүйрэлд хүрэх зам, харин эв нэгдэл бол тусгаар тогтнол цэцэглэл хөгжилд хүрэх зам мөн. Өнөөдөр манай үндэстний хувьд нэгдлээс илүү эрхэм зүйл үгүй, эх орноо сэргээн нэгтгэхээс илүү амин чухал зорилт үгүй байна»<sup>1</sup> гэж заасан юм.

Солонгосын асуудлыг шийдвэрлэхэд ахиц дэвшил гарахгүй байгаагийн учир шалтгаан чухам юунд байна вэ? 1971 оны наймдугаар сард Пханмунжонд эхэлсэн Умард, Өмнөдийн яриа хэлэлцээ яагаад үр дүнд хүрэхгүй, тасалдалд ороод байна вэ? 1975 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXX чуулганаас баталсан Өмнөд Солонгосоос гадаадын бүх цэргийг гаргаж, гал зогсоох тухай 1953 оны долдугаар сард Пханмунжонд гарын үсэг зурсан хэлэлцээг дагаж мөрдөх тухай шийдвэр одоо болтол хэрэгжихгүй байгаагийн учир юу вэ? гэсэн асуулт зайлшгүй тулгарч байна. Бүх учир шалтгаан АНУ-ын империализм Солонгосын ард түмний дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцож байгаад оршино. АНУ-ын хөндлөнгийн энэ оролцоо Өмнөд Солонгосын хамгийн харгис хүчнийг хөхүүлэн дэмжиж, америкийн талыг баримталсан Сеулийн харгис дэглэмийг оршин тогтноход хүргэж байгаа учраас улам ч аюултай шинжтэй юм.

<sup>1</sup> Ким Ир Сен, Отчетный доклад Центрального Комитета Трудовой Партии Кореи VI съезду партии, Корея, Пхеньян, 1980, 81 дэх тал.

\* \* \*

Сүүлийн арваад жилд Ази тивд гарсан дэвшилт нааштай өөрчлөлтүүд, америкийн империализмын стратегийн байр суурь Өмнөд Солонгост бэхжиж байгаатай давхцаж байгаа юм. Нэгдмэл социалист Вьетнам улс байгуулагдсан, Лаос орон социализмын ертөнцөд нэгдэн орсон, Кампучид ардын хувьсгал ялж тус орон энх тайван социализмын замаар гуйвалтгүй замнаж байгаа. Зүүн өмнөд Ази-Алс Дорнодын цэргийн түрэмгий СЕАТО эвсэл, Баруун өмнөд Ази-Дундад Дорнодын цэргийн гэрээний СЕНТО эвсэл задран унасан болон Афганистан, Иран дахь империализмыг эсэргүүцсэн хувьсгал, Энэтхэг улсын энхийг эрхэмлэгч, эвсэлд үл нэгдэх гадаад бодлого зэрэг нь Ази тив дэх АНУ-ын стратегийг хүчтэй ганхуулсан билээ. Ингээд Солонгосын хойгийн өмнөд хэсэг Ази дахь америкийн сүүлчийн түшиц газар болоод байна. Өмнөд Вьетнамын Сайгоны дэглэм сүйрэн унасны маргааш нь л, АНУ-ын тэр үеийн Батлан хамгаалах Яамны сайд Шлессинжер «Вьетнамаас АНУ гарсны дараа манай батлан хамгаалах фронтын бүс Баруун Европ, Өмнөд Солонгос боллоо»<sup>2</sup> гэж мэдэгдсэн нь дээрхийг нотлож байна.

АНУ-ын Ази дахь бодлогын стратегийн гол зорилго нь дэлхийн бөмбөрцөгийн энэ районд зөвлөлтийн эсрэг холбоо эмхлэн байгуулах явдал болж байна. Дэлхий дахинд болон Ази тивд энх тайван, дайны хүчний харьцаанд гарсан гол гол өөрчлөлтийн хирээр Өмнөд Солонгос дахь Сеулын дэглэмд гол үүрэг оногддог болж байна. АНУ-ын гол түшиц газрын хувьд Өмнөд Солонгосын «тогтоон барих хүчний бодлого» зонхилж байсан далаад оны эхнээс Америкийн Ази дахь хуучин түнш—Япон зөвлөлтийн эсрэг цэргийн хэлхээ холбоонд нэгдэн орох болсон юм. 1965 онд Япон—Өмнөд Солонгосын харилцаа хэвийн болсноос хойш хоёр талын цэргийн хэлхээ холбоо идэвхжсэн байна.

Солонгосын хойг Алс Дорнод дахь түгшүүртэй байдлын голомт хэвээр байж, Солонгосын ард түмний хэрэгт гаднаас хөндлөнгөөс оролцож байгаагийн гол хүчин зүйл бол Солонгосын өмнөд хэсэгт цөмийн хөнөөн сүйтгэх зэвсэг бүхий америкийн цэрэг байрлаж байгаа явдал юм. Албан ёсны эх сурвалжаас үзвэл тэнд байгаа АНУ-ын 40 гаруй баазад 40 гаруй мянган цэргийн албан хаагч байрлаж байгаа ажээ. АНУ-ын хуурай замын цэргийн тус хойг дээр байгаа 8 дугаар арми нь 28500 хүнтэй түүний бүрэлдэхүүнд хүчжүүлсэн явган дивиз, артиллер, пуужингийн тусгай бригад орж байна. Мөн Япон, Өмнөд Солонгос дахь байлдааны тэргүүн шугам гэгчид АНУ-ын агаарын цэргийн 5 дугаар арми, 8 дугаар армид агаараас дэмжлэг үзүүлэх зориулалттай байрлаж байна<sup>3</sup>.

Солонгост байлдааны гал зогсоох тухай хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш 30 гаруй жилийн турш Вашингтоныхон олон улсын хамтын нийгэмлэгийн шийдвэр, дэлхийн олон нийтийн хүсэл бодлыг зөрчиж, Солонгосын хойгоос цэргээ гаргахаас байнга цааргалж хоёр Солонгосын хилийн дагуу гал зогсоосон, цэрэггүй бүст БНАСАУ-ын эсрэг чиглэсэн өдөөн хатгалга удаа дараа үйлдэж, байдлыг улам хурцатгаж байна. Далаад оны дундуур Өмнөд Солонгос дахь америкийн цэрэг зэвсэглэлдээ цөмийн 150 цэнэгтэй болж цөмийн артиллери (цөмийн

<sup>2</sup> «Нью-Йорк таймс 1. V. 1975

<sup>3</sup> «Улаан од» 1983. VIII. 3

цэнэг буудах их бууны тусгай анги нэгтгэл гэсэн үг—Д. Б.) гэгчээ байгуулан 155 мм, 175 мм, 203 мм-ийн гаубиц<sup>4</sup> буу 70-тай болж, зөвхөн их буунд 210 цөмийн цэнэг хуримтлуулж, цөмийн 162 цэнэгтэй хушуу бүхий «газар—газар» ангиллын «Сержант», «Ланс», «Найк Геркулес» пуужингийн 150 суурь нэг бүр нь дөрөв хүртэл цөмийн бөмбөг тээдэг сөөнгөч—бөмбөгдөгч Ф—4 «Фантом» нисэх онгоц 54-тэй болжээ. Ингээд нийтдээ америкийн армийн командлалын мэдэлд 700 илүү цөмийн цэнэг байгаа ажээ.<sup>5</sup>

«Өмнөд Солонгос бол асар том бааз, нарийн хэлбэл цөмийн зэвсгийн цогцолбор бааз юм» гэж 1983 оны дөрөвдүгээр сард Москвад хийлгэсэн хэвлэлийн бага хурал дээр ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга, Гадаад явдлын Яамны сайд А. А. Громыко тэмдэглээд, америкийн цөмийн Ази дахь баазууд ЗХУ-ыг ямаршуу байдлаар бүсэлсэн, Сибирийн бүх нутаг, зөвлөлтийн нутгийн Азийн хэсэг, тэр ч байтугай хамгийн хойд нутаг—Таймырын хойг хүртэл америкийн цөмийн пуужингийн тусгал дор байгааг сануулсныг энд дурдах нь зүйтэй.<sup>6</sup> Тэгээд ч эвдлэн сүйтгэх хүчин чадлаараа асар хөнөөлтэй эдгээр хүч нь Солонгосын хойгоос ЗХУ, Азийн бусад оронд цохилт өгөх Вашингтоны цөмийн нударгад тооцогдож байгаа юм. Ер нь АНУ-ын империалистууд Солонгосын хойг, түүний ойр орчмын баазуудаа 1000 гаруй цөмийн зэвсэг байрлуулж, хэтдээ Сеулын фашист дэглэмийг цөмийн зэвсэгтэй болоход нь туслан, атомын реактор нийлүүлж, улмаар тус бүс нутагт халуун цөмийн аюул бий болгож байгаа мэдээ ч бий.<sup>7</sup> Америкийн хэвлэлийн мэдээгээр Рейганы засаг захиргаа Өмнөд Солонгост нейтроны цэнэг бүхий пуужин, их буунд зориулсан нейтроны сум, тэргүүн байрлалын дунд зайны тусгалтай цөмийн баллистик «Першинг» пуужин байрлуулахаар төлөвлөж байгаа ажээ.

Алс Дорнодод байгаа америкийн цэргийн тоо байнга нэмэгдэж, зөвхөн сүүлийн хоёр жилд 11 мянгаар өсч, одоо 135000-д хүрээд байгаагийн 45 мянга нь Японд, түүнээс 30 мянга нь Окинава арал дээр бөөгнөрөөд байна. Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлал байлдааны 140 хөлөг онгоц нисэх онгоц тээгч 6 хөлөг, цөмийн пуужин бүхий атомын шумбагч олон завь, 1125 нисэх онгоц, нийт 465 мянган цэргийн албан хаагчийг мэдэлдээ барьж байна.<sup>8</sup>

Пентагоны алс дорнодын стратеги гэгчийн хүрээнд одоо ид хэрэгжүүлж байгаа «шинэхэн төлөвлөгөөний» дагуу Өмнөд Солонгос дахь Америкийн цэргийн хүчин чадлыг нэмэгдүүлж, бэхжүүлэх нүсэр ажил явагдаж байна. «АНУ-ын хувьд Солонгосын хойг стратегийн чухал ач холбогдолтой» гэж үзэж буй Пентагоны дээрх төлөвлөгөө ёсоор, сөнөөгч—бөмбөгдөгч «Ф—16» нисэх онгоцны хоёр эскадриль (нийт 100 гаруй онгоц), түүнийг агаарт хамгаалдаг дайрагч «А—10» нисэх онгоцны нэг эскадриль нэмж байрлуулах, «стратегийн агаарын хяналтын пункт» бий болгох, тэнгисийн цэргийг хоёр дахин нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ оржээ.

Өмнөд Солонгост тагнуулын хорлон сүйтгэх томоохон бааз байгуулах тухай Пентагоны шийдвэр бол онц аюултай алхмын нэг мөн. Үүнтэй холбогдуулан АНУ-ын Батлан хамгаалах Яамны сайд К. Уайнбергериин хийсэн хоёр мэдэгдлийг авч үзье. Тэр «Бид АНУ-ын амин чухал эрх ашгийг хөндсөн ямар ч үед, ямар ч тохиолдолд дэлхийн

<sup>4</sup>Гаубиц—том калибрийн алсын тусгалтай их буу.

<sup>5</sup>«Проблемы Дальнего востока» 1982, №2, 107 дахь тал

<sup>6</sup>Пресс—конференция А. А. Громыко, «Правда» 4. IV. 1983.

<sup>7</sup> «Нодонсинмун» 1981. XII. 3.

<sup>8</sup> Откуда исходит угроза миру, Москва., 1982, 15 дахь тал

ямар ч өнцөг буланд дайн хийх чадварыг эзэмшсэн байх ёстой»<sup>9</sup> «Хэрэв Солонгосын хойгт дайн гарвал АНУ солонгосын фронтод хуурай зам, тэнгис, агаарын 100 мянган цэрэг, маневрийн цохилтын салбарын хамт илгээнэ»<sup>10</sup> гэжээ. Пентагоны толгойлогчийн энэ мэдэгдэл чухам юунд, тэгэх тусмаа хэнд чиглэснийг тайлбарлах юун. Солонгосын өмнөд хэсэгт одоо байгуулж эхлээд байгаа тагнуулын хорлон сүйтгэх бааз нь БНАСАУ дахь социалист бүтээн байгуулалтыг тасалдуулах, Зүүн—хойд Хятад, улмаар ЗХУ-ын Сибирь, Алс дорнодын районд америкийн империализмын хийж мэдэх ирээдүйн ямар нэг «болзошгүй ажиллагаанд» шууд үйлчлэх ёстой ажээ. Ийм зориулалттай электрон—тагнуулын отрядуудыг тийш нь хэдий нь явуулаад байгаагаас гадна уг отрядад үүрэг гүйцэтгэх 1500 цэргийг бэлтгэлд байна. Үүний зэрэгцээ «маневрийн цохилтын анги салбар» гэдэг нэрийн дор Пентагоны стратегчид цохилтын шинэ бүлэглэл байгуулж байгааг К. Уайнбергер дээрх мэдэгдэлдээ дурдсан. «Маневрийн цохилтын салбарын» цэргийн албан хаагчдад тусгайлан солонгос хэл заадаг бөгөөд тэд ч солонгосын талаар нилээд «мэргэжсэн» хүмүүс буюу хэрэг дээрээ мэргэжлийн тагнуулчид болдог байна.

Америкийн империалистууд Өмнөд Солонгос дахь Чон Ду Хваны цэрэг—хүнд суртлын тоглоомын дэглэмийг «үг дуугүй» дэмжихээ шууд зарлаж, түүний зэвсэгт хүчнийг «шинэчлэх» томоохон программ хэрэгжүүлж байгаа юм. Одоо Өмнөд Солонгосын байнгын армид 700 мянган цэрэг офицер алба хааж, «орон нутгийг хамгаалах бэлтгэл арми» гэгчид 3,5 сая хүн, үүний дээр 500 мянга орчим цэрэгжүүлсэн цагдаа ингээд нийт 4,7 сая хүн тус улсын зэвсэгт хүчинд тооцогдож байгаагаас үзэхэд цэргийн бие бүрэлдэхүүний тоогоор Өмнөд Солонгос нь Алс Дорнод, далайн орнууд төдийгүй дэлхий дээр дээгүүр орон болж байна.<sup>11</sup> 1978 оны арваннэгдүгээр сард «Америк—Солонгосын зэвсэгт хүчний нэгдсэн командлал» байгуулсныг албан ёсоор зарлаж, цэргийн бүхий л арга хэмжээг хэмтран төлөвлөн явуулдаг болсон байна. Солонгос орныг Японы колоничлолын дарлалаас чөлөөлснөөс хойш 38 жилийн турш «НҮБ-ын цэргийн» халхавчийн дор Өмнөд Солонгост америкийн цэрэг байрлаж, мөн энэ хугацаанд Сеулын ард түмэнд ад үзэгдсэн дэглэмийн цэргийн зардал төсөв, цэргийн тусламж гэгчийг шат дараалан өсгөж, тус орныг бүхэлд нь цэрэг цагдаа, хуаран, шорон гяндангаар дүүрэгжээ.

1946—1979 оны хоорондох 33 жилийн дотор Вашингтоноос тийш нь үзүүлсэн эдийн засаг—цэргийн тусламжийн хэмжээ 14 миллиард 681 сая доллар болсон баримтыг л аваад үзье. Энэ бол асар их зардал юм». Чон Ду Хваны дэглэмд 900 сая долларын өртөг бүхий «М—551» маягийн 1000 танк, «Ф—16» сөнөөгч—бөмбөгдөгч 36 нисэх онгоц, мөн байлдааны эсминц хөлөг нийлүүлэх шийдвэр гарчээ. Цаашдаа хоёр миллиард долларын үнэтэй цэргийн техник, үүний дотор «Хок» маягийн шинэ пуужин нийлүүлэх төлөвлөгөөг Вашингтонд боповсруулаад байна. 1981 онд Өмнөд Солонгосын тоглоомын дэглэмд 150 сая долларын цэргийн тусламж үзүүлж, 1982 онд 166 сая доллар, 1983 онд энэ зардлыг 210 сая доллараар төсөвлөж, 1984 оны санхүүгийн жилд 230 сая долларт хүргэх бодолтой байна.<sup>12</sup>

Эдүгээ Өмнөд Солонгосыг дэлхий дээрх хамгийн их цэрэгжсэн милитарист улсын нэг гэж тооцвол зохино. Тэнд өдөр бүр шахуу

<sup>9</sup>Меморандум МИД КНДР, Пхеньян.. 1981. орос хэл дээрээс дам авав.

<sup>10</sup>Мөн тэнд

<sup>11</sup>«Корея сегодня» № 6. 1981, хавсралт дээр

<sup>12</sup>«Новое время №27, 1983. 2 дэх тал.

явагддаг Иргэний хамгаалалтын сургууль, бэлтгэл армийг яаралтай дайчлах дадлага» «партизаны сургууль» «албан хаагчдыг сургах сургууль» гэгчид тус улсын бараг бүх иргэн-найман настай балчраас 80 настай хөгшдийг хүртэл хаман дайчилж, умардын эсрэг ирээдүйн «аян дайн» гэгчдээ бэлтгэдэг ажээ. Солонгосын хуваагдмал байдлыг үүрд хэвээр байлгах зорилгоор коммунизмын эсрэг үзлийг дэвэргэж, БНАСАУ дахь социализмын байгуулалтын эсрэг үзлээр Өмнөд Солонгосын хүн амыг мунхруулан хордуулахад Сеулын суртал нэвтрүүлгийн бүхий л хэрэгслийг шавхан ашиглаж байна. Цэргийн аж үйлдвэрийг хөгжүүлэх далбаан дор иргэний хэрэгцээний үйлдвэр заводыг цэрэгжүүлэх, шинэ шинэ зам гүүр, аэродром, бааз объект барьж байгуулах, үүндээ өрнөдийн капиталист орнуудаас тусламж дэмжлэг авах гэж оролдсоор байна.

Японд дэлхийн хоёрдугаар дайнаас хойш үзэгдээгүй хэмжээгээр хонзогнох үзэл, милитаризмыг дэвэргэж, «умардын аюулыг сөрөн эсэргүүцэх» цэрэг дайны зорилгын үүднээс Японы эрх баригчид Сеулийн дэглэмийг улам бүр сонирхох болж байна. Япон, Өмнөд Солонгосын хооронд 1969 онд анх цэргийн харилцаа тогтож, 1971 оноос цэргийн мэдээ тогтмол солилцох болж 1976 онд америкийн дэмжлэгээр Япон—Өмнөд Солонгосын радиолокацийн систем байгуулж, 1977 онд анх удаа АНУ, Япон, Өмнөд Солонгосын тэнгисийн хамтарсан сургууль хийж, үүнээс хойш хоёр талын цэргийн дээгүүр тушаалтны зохицуулах зөвлөлгөөнийг жилд хоёр удаа хийдэг болсон байна. 1979 онд Японы Үндэсний Батлан хамгаалах Газрын дарга анх удаагаа Сеулд очиж, Аюулгүй байдлын асуудлаарх Япон—Өмнөд Солонгосын парламентийн зөвлөл байгуулагджээ. Одоогийн байдлаар Японы цэрэг-аж үйлдвэрийн 40 орчим кампани, концерн Сеултэй хамтран ажиллаж, байлдааны техник, артиллери буудлагын зэвсэг, сум галт хэрэгслээр хангаж байна.<sup>13</sup> «Нитсин» гэдэг ган цувималын компаниас танканд зориулсан 30 тонн ган хуяг авчээ.<sup>15</sup>

«Америк—Солонгосын зэвсэгт хүчний нэгдсэн командлал» гэгчээс Солонгосын хойг түүний ойр орчмын усан хилд БНАСАУ, Ази тивийн бусад улс түмнийг илт өдөөн хатгасан шинжтэй тактикийн хээрийн сургуулийг «Тим спирит» томъёолсон нэрийн дор жил бүр явуулдаг болсон нь Вашингтон—Сеул—Токиогийн цэрэг—стратегийн хамтын ажиллагаа өргөжиж илэрхий түрэмгий шинжтэй болж байгааг харуулж байна. 1983 оны ийм сургууль үргэлжилсэн хугацаа, оролцсон хүн хүч, шинж чанараараа урьд өмнө үзэгдээгүй хэмжээнд хүрсэн юм. «ТИМ СПИРИТ—83» сургуульд америкийн 73 мянга орчим цэрэг, Өмнөд Солонгосын 188 мянган цэрэг, мөн Японы өөрийгөө хамгаалах хүчний штаб оролцсон юм. Мөн тийш нь АНУ, Гавайн арлууд, Японоос «түргэн цөмрөх хүчний» хэд хэдэн дивизийг татан аваачиж, тактикийн цөмийн зэвсэг, химийн зэвсэг хэрэглэсэн «нөхцөлд» цэргийн зориулалттай ачаа барааг АНУ-ын нутгийн гүнээс болон Номхон далайн Гуам, Гавайн арлуудаас Япон, Филиппин хүртэл татан буулгах, цэргийн хүчийг өргөтгөн задлах зорилгоор десант хаях, түшиц газар эзлэн авч, том хэмжээний давших операцыг явуулах зэрэг тактик боловсруулсан

<sup>13</sup> «Красная звезда» 21. III. 1981.

<sup>14</sup> «Иоури симбун» 5. II. 1981.

<sup>15</sup> «Иоури симбун» 19. II. 1981.

байна.<sup>16</sup> Энэ удаагийн «Тим спирит» сургууль Өрнөд Европт жил бүр хийдэг НАТО-гийн цэргийн «Отэм форж» хээрийн сургуулиас илүү том хэмжээнд болсон нь санамсаргүй хэрэг биш бөгөөд ерөөсөө сүүлийн найман жил дараалан хийсэн «Тим спирит сургуулиудын зорилго нь ус агаар, хуурай газраар БНАСАУ, ЗХУ-ын Алс Дорнод Азийн бусад районд «хэрэгцээтэй тохиолдолд» буюу Уайнбергериин хэлсэнчлэн АНУ-ын амин чухал эрх ашгийг хөндсөн үед дайрч довтлох түрэмгий төлөвлөгөө боловсруулахад шууд чиглэж байна.

Түүх хүн төрөлхтнийг сонор сэрэмжтэй байхыг ямагт сануулж байсан нь зүйн хэрэг билээ. Тэр дундаа Азийн улс түмэнд дайн милитаризм ямар хор уршигт хүргэж байсныг харахгүй өнгөрч болохгүй байсныг Дайнаас хойшхи бүхий л үеийн турш Азийн улс түмэн, түүний аюулгүй байдалд АНУ-ын империализм гол аюул болж, ноёрхлоо тогтоохын тулд бүрэлдэн тогтсон нөхцөл байдлыг ашиглах гэж оролдож ирсэн билээ. 1950—1953 онд БНАСАУ-ын эсрэг өдүүлсэн түрэмгий дайн, энэ дайны үеэр Солонгос болон Хятадын нутагт атомын бөмбөг хаяхаар санаархаж байсан америк генерал Макартурыг хүн төрөлхтөн мартаггүй, жигшин зэвүүцсээр байх болно. АНУ-ын эрх баригч бүлгийнхэн социализм үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хазаарлан зогсоож, нухчин дарах зорилгоор Вьетнам, Зүүн өмнөд Азийн бусад улс оронд дээрмийн дайн дэгдээсэн юм. Вьетнамын дайны фронтод 38 мянган цэргийн томоохон хүчийг оруулж энэтхэг-хятадын хойгийн ард түмний эсрэг аллага хядлагад шууд оролцож байсан Сеулын тоглоомын дэглэм Вашингтоны эздийнхээ ивээлээр ямар ч бузар явууллага үйлдэхэд бэлэн байгаага дэлхий нийтэд харуулсан юм.

Олон улсын одоогийн нэн нарийн ээдрээтэй нөхцөл байдалд Өмнөд Солонгосын цэргийн дэглэмийг цэрэгжүүлж, илэрхий цэнэглэн турхирах нь Азийн улс түмний хувь заяа хурцадмал байдлын ирмэг дээр дэнжигнэх осолтой байдалд хүргэж болзошгүй юм. **Түгшүүртэй байдал, бэрхшээл, дайн үүсэх аюул занал ихэсч, дайны голомт болон хувирч байгаа явдал Солонгосын хойгийн тодорхой шинж болоод байна.**

Түгшүүртэй байдлыг хурцатган даамжруулах империалист бодлого эцсийн эцэст ямар ч явцгүй, хэтийн төлөвгүй юм. Ялангуяа Ази тив, Алс Дорнодод дайны замыг хааж, энх тайвны төлөө тулалдаанд хожих бодит боломж бий. Хүч нөөц ч бий. Солонгосын хойгийг нийтэд нь энх тайван, итгэлцлийн бүс болгоход чиглэсэн оновчтой санал санаачлагуудыг БНАСАУ дэвшүүлж байгаа бөгөөд Алс Дорнод, Ази тивийн байдлыг тогтворжуулахад тус нэмэр болох тэдгээр саналыг энхийг эрхэмлэгч олон нийт өндрөөр үнэлж, дэмжиж байдаг билээ.

БНМАУ-ын тухайд ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бүх улс оронтой болон дэвшилт бүх улс түмэнтэй хамт энх тайван олон улсын аюулгүй байдлын эрхэм зорилгыг хамгаалж байна. Нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хуралд тавьсан тайлан илтгэлдээ: «Манай орон БНАСАУ-тай найрамдалт харилцаагаа бэхжүүлэх чиг бодлогыг гуйвалтгүй баримталж байна. Үндэснийхээ хүсэл эрмэлзлийг биелүүлэхийн төлөө, улс орноо эв зүйгээр ардчилсан ёсоор, гадны оролцоогүйгээр нэгтгэхийн төлөө Солонгосын ард түмний тэмцлийг бид хойшид ч тал бүрээр дэмжих болно гэж онцлон тэмдэглэсэн билээ.

<sup>16</sup> «Красная звезда» 6. II. 1983.

<sup>17</sup> МАХН-ын XVIII их хурал. УБ. 1981. 27 дахь тал

## ЮЖНАЯ КОРЕЯ—ОЧАГ НАПРЯЖЕННОСТИ НА ДАЛЬНЕМ ВОСТОКЕ

### (Р е з ю м е)

Нормализация обстановки и обеспечение безопасности на Корейском полуострове остается одной из важнейших проблем международной политики на Дальнем Востоке.

Уже в течении трех десятилетий при поддержке американского империализма в Южной Корее стоит у власти антинародный диктаторский режим. Действуя по указке Вашингтона, марионеточное правительство Южной Кореи превратило страну в американскую военную базу, в стратегический плацдарм США, используемый для увеличения своего военного присутствия в этом регионе. Стратеги из Вашингтона видят в лице Южной Кореи надежного «партнера» в реализации своих опасных замыслов, ведущих к нагнетанию напряженности и раскручиванию гонки вооружений на Тихом океане.

Тревогу у народов Азии вызывает растущее сближение сеульского режима с Токио, которое происходит под эгидой США и носит ярко выраженную форму военного союза. Этот альянс, в рамках которого проводятся военные маневры, происходит обмен военной технологией, возрождается милитаризм, направлен своим острием против социалистических стран и прогрессивных правительств Азии.

Сохраняющаяся напряженность на Корейском полуострове чревата опасностью возникновения конфликтов, и это вызывает глубокую озабоченность у народов соседних стран.

Страны социалистического содружества, в том числе и наша страна, приветствуют усилия КНДР по ослаблению напряженности и урегулированию отношений с Южной Кореей.

«Наша страна—отмечается в Отчетном докладе ЦК МНРП XVIII съезду партии— неизменно проводит курс на укрепление дружественных взаимоотношений с КНДР. Мы будем и впредь всемерно поддерживать борьбу корейского народа за осуществление своих национальных чаяний, за мирное, демократическое объединение страны без вмешательства извне».